



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/147/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

аудитор: Д.Мөнхтулга

Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БААСАНХҮҮ ТАНАА

2025.03.14 № 2104
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Сөрөг дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 60 дугаар зүйлийн 60.3.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалттай нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын А/260, А/261, А/302, А/812 тоот захирамжаар 128,316.0 мянган төгрөгөөр Засаг даргын үйл ажиллагааны тайлан сэтгүүл болон сонин хэвлүүлэхдээ Засгийн газрын тогтоолоор баталсан босго үнээс давсан байхад тусдаа гэрээ байгуулан худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй;
- Аймгийн Засаг даргын А/201 тоот захирамжаар 19,500.0 мянган төгрөгийн гэрээг Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоотой байгуулсан ч гэрээний үүргийн биелэлтийг тооцоогүй;
- Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалин хөлсөнд 96,945.5 мянган төгрөг олгосон ч буруутай этгээдээс буцаан нэхэмжлээгүй;
- Аймгийн Засаг даргын А/132, А/818, А/251 тоот захирамжуудаар эмэгтэйчүүдийн холбоонд 55,236.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ч санхүүгийн анхан шатны баримт дутуу;

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр байгууллагын урсгал зардалд 20,000.0 мянган төгрөг зарцуулан программын эрх авсан ч ашиглахгүй үрэлгэн зардал санхүүжүүлсэн;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төрийн албан хаагчдыг БНХАУ-ын Үрэмч хотод аялуулахад 108,414.8 мянган төгрөгийг зарцуулсан;
- Байгууллагын шатахууны тооцоог хянаагүй, жолоочийн замын хуудас бүрэн хөтлөөгүй 48,275.6 мянган төгрөг;

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд ангийн дуудлага худалдааг цахимаар зохион байгуулж орон нутгийн төсөвт 1,281,102.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,181,351.6 мянган төгрөгийн өртөг бүхий спорт заалны барилга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,453,269.6 мянган төгрөгийн өртөгтэй аймгийн төвийн камержуулалтын төхөөрөмжийг хүлээн авсан байна.

Тайлант онд Шим-Ус ОНӨААТҮГ-тай холбоотой 541,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулан ажиллажээ.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,793,900,959.79</u>	<u>3,313,107,330.73</u>
33	АВЛАГА	1,300,473,177.82	2,086,302,826.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,238,892.07	2,274,465.88
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,036,951,035.06	1,689,800,475.18
335	Бусад авлага	259,283,250.69	394,227,884.94
3351	Байгууллагаас авах авлага	259,283,250.69	297,282,527.94
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	96,945,357.00
34	УРЬДЧИЛГАА	660,238,600.00	211,729,889.00
34600	Урьдчилж гарсан зардал	659,838,600.00	211,329,889.00
3471	Урьдчилгаа тооцоо	400,000.00	400,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	400,000.00	400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	304,942,356.97	374,719,998.73
354	Хангамжийн материал	288,883,236.97	340,480,998.73
35410	Бичиг хэргийн материал	1,046,700.00	1,141,000.00
35420	Аж ахуйн материал	145,000.00	1,545,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	23,737,650.00	17,707,650.00
35450	Барилгын засварын материал	75,633,400.00	73,541,400.00
35460	Хүнсний материал	97,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	188,223,486.97	246,545,948.73
35600	Мал амьтад	16,059,120.00	34,239,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	528,246,825.00	640,354,617.00
36100	Барааны нөөц	29,762,325.00	29,578,325.00
36300	Тэжээлийн нөөц	498,484,500.00	610,776,292.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,511,262,512.75</u>	<u>9,084,073,891.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,511,262,512.75	9,084,073,891.09
392	Биет хөрөнгө	4,696,194,912.08	8,208,440,957.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,533,867,127.00	4,742,251,010.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(601,927,203.44)	(699,719,068.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	582,324,024.00	754,124,024.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(502,324,857.64)	(578,818,746.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	843,798,246.90	3,036,099,726.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(406,650,277.42)	(560,390,003.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	258,606,697.52	317,090,069.00

39208	Хуримтлагдсан элэгдэл	(209,792,325.25)	(211,921,423.54)
39209	Зам, гүүрний байгууламж	271,738,906.07	283,652,490.07
39210	Хуримтлагдсан элэгдэл	(135,038,149.76)	(137,746,288.71)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	29,289,700.00	29,289,700.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(3,497,041.71)	(3,497,041.71)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	973,720,000.00	973,720,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	129,262,460.00	355,611,135.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(67,182,394.19)	(91,304,625.13)
393	Биет бус хөрөнгө	815,067,600.67	875,632,933.29
39301	Программ хангамж	17,886,115.00	122,886,115.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(17,886,114.33)	(42,052,781.71)
39303	Бусад биет бус хөрөнгө	815,067,600.00	794,799,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,305,163,472.54</u>	<u>12,397,181,221.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>79,507,999.06</u>	<u>5,467,481.63</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	79,507,999.06	5,467,481.63
413	Өглөг	79,507,999.06	5,467,481.63
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,468,753.06	1,246,330.62
4136	Бусад өглөг	76,039,246.00	4,221,151.01
41361	Байгууллагад төлөх өглөг	1,626,150.00	4,221,151.01
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	74,413,096.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,225,655,473.48</u>	<u>12,391,713,740.19</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,225,655,473.48	12,391,713,740.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,829,163,598.00	2,808,895,598.00
51101	Өмч: - төрийн	2,829,163,598.00	2,808,895,598.00
512	Хуримтлагдсан үр дүн	4,246,607,587.79	8,432,933,854.50
51210	Өмнөх үеийн үр дүн	1,954,204,502.00	4,211,607,587.79
51220	Тайлант үеийн үр дүн	2,292,403,085.79	4,221,326,266.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,149,884,287.69	1,149,884,287.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,305,163,472.54</u>	<u>12,397,181,221.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,026,199,090.26	16,471,978,156.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,694,121,880.26	4,571,542,847.20
120	Нийтлэг татварын бус орлого	1,694,121,880.26	4,571,542,847.20

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,694,121,880.26	4,571,542,847.20
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,954,020.00	9,190,133.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,685,167,860.26	4,562,352,714.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,332,077,210.00	11,900,435,309.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,964,791,700.00	5,184,862,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,964,791,700.00	5,184,862,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,367,285,510.00	6,715,573,009.44
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,006,043,877.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,059,515,462.00	3,606,541,469.94
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,227,681,943.00	1,083,196,692.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,080,088,105.00	19,790,970.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,728,511,282.54	11,880,439,418.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,728,511,282.54	11,880,439,418.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,468,552,197.71	11,194,059,489.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,895,502,277.68	2,902,193,089.34
210101	Үндсэн цалин	1,123,950,854.94	1,685,935,505.40
210102	Нэмэгдэл	621,842,643.36	916,449,791.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,013,000.00	103,543,500.00
210104	Урамшуулал	100,823,648.00	196,086,560.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,872,131.38	177,732.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	223,128,502.77	346,468,147.08
210201	Тэтгэврийн даатгал	150,325,137.26	234,023,789.25
210202	Тэтгэмжийн даатгал	18,218,175.85	27,693,841.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,336,940.60	15,466,360.81
210204	Ажилгүйдлийн даатгал	3,465,708.85	12,979,291.53
210205	Эрүүл мэндийн даатгал	36,782,540.21	56,304,863.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,097,558.00	536,105,109.88
210301	Гэрэл, цахилгаан	41,691,297.15	51,417,233.53
210302	Түлш, халаалт	189,401,059.80	450,552,730.80
210303	Цэвэр, бохир ус	21,005,201.05	34,135,145.55
2104	Хангамж, бараа материалын зардал	255,496,976.17	239,532,475.05
210401	Бичиг хэрэг	17,616,005.00	8,892,400.00
210402	Тээвэр, шатахуун	220,473,301.17	211,427,235.05

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,810,970.00	18,397,840.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	560,000.00	740,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,700.00	75,000.00
2105	Нормативт зардал	2,275,052.00	80,001.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,275,052.00	80,001.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,132,842.00	33,164,100.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	180,000.00	265,000.00
210604	Урсгал засвар	5,952,842.00	32,899,100.01
2107	Томилолт, зочны зардал	78,644,534.00	68,581,000.00
210702	Дотоод албан томилолт	78,644,534.00	68,581,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,455,354.00	81,373,384.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,341,582.00	60,147,935.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,744,812.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,785,200.00	3,139,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	353,860.00	954,680.40
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	327,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,226,900.00	8,711,880.00
210807	Газрын төлбөр	959,000.00	8,092,589.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,631,819,101.09	6,986,562,182.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,365,111,485.57	6,575,174,520.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,410,000.00	4,578,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	262,297,615.52	406,809,161.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	259,959,084.83	686,379,929.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,225,300.00	347,445,938.33
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	126,667,900.00	55,485,742.33
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	257,883,636.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,257,400.00	34,076,560.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	128,733,784.83	185,785,288.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	128,733,784.83	185,785,288.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	153,148,703.00

213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	153,148,703.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,297,687,807.72</u>	<u>4,591,538,737.79</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,284,721.93	370,212,471.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,284,721.93	182,538,671.08
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	187,673,800.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,284,721.93)	(370,212,471.08)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,292,403,085.79</u>	<u>4,221,326,266.71</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	2,858,431,598.00	1,149,884,287.69	1,924,936,500.90	5,933,252,386.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	29,268,001.10	29,268,001.10
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,858,431,598.00	1,149,884,287.69	1,954,204,502.00	5,962,520,387.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(29,268,000.00)	-	-	(29,268,000.00)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,292,403,085.79	2,292,403,085.79
C08	2023 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	2,829,163,598.00	1,149,884,287.69	4,246,607,587.79	8,225,655,473.48
D01	2023 оны 1-р сарын 1-нээх үлдэгдэл	2,829,163,598.00	1,149,884,287.69	4,246,607,587.79	8,225,655,473.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(35,000,000.00)	(35,000,000.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,829,163,598.00	1,149,884,287.69	4,211,607,587.79	8,190,655,473.48
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(20,268,000.00)	-	-	(20,268,000.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	4,221,326,266.71	4,221,326,266.71
D09	2024 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	2,808,895,598.00	1,149,884,287.69	8,432,933,854.50	12,391,713,740.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>9,100,385,761.00</u>	<u>13,001,924,077.44</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,954,020.00	9,190,133.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,954,020.00	9,190,133.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,954,020.00	9,190,133.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,954,020.00	9,190,133.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,091,431,741.00	12,992,733,944.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,964,791,700.00	5,184,862,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,964,791,700.00	5,184,862,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,126,640,041.00	7,807,871,644.44
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,006,043,877.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,059,515,462.00	3,606,541,469.94
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,227,681,943.00	1,083,196,692.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,839,442,636.00	1,112,089,605.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>9,080,885,761.00</u>	<u>13,001,924,077.44</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,080,885,761.00	13,001,924,077.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,781,273,041.11	10,546,530,576.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,884,092,739.00	2,903,594,916.80
210101	Үндсэн цалин	882,260,069.98	1,518,241,877.08
210102	Нэмэгдэл	744,101,259.23	1,102,031,753.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,935,396.08	104,474,039.19
210104	Урамшуулал	100,970,651.11	170,173,562.12
210105	Гэрээт ажлын хөлс	126,825,362.60	8,673,684.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	216,632,898.50	345,174,316.97
210201	Тэтгэврийн даатгал	151,946,454.38	243,404,827.07
210202	Тэтгэмжийн даатгал	10,861,407.19	23,390,339.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,242,861.26	17,578,657.54
210204	Ажилгүйдлийн даатгал	3,559,816.99	5,327,730.64
210205	Эрүүл мэндийн даатгал	36,022,358.68	55,472,762.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	284,977,700.00	547,497,264.42
210301	Гэрэл, цахилгаан	48,235,697.15	58,967,233.53
210302	Түлш, халаалт	201,913,059.80	451,752,730.80
210303	Цэвэр, бохир ус	34,828,943.05	36,777,300.09

2104	Хангамж, бараа материалын зардал	116,887,100.00	142,605,540.46
210401	Бичиг хэрэг	15,000,000.00	24,486,205.00
210402	Тээвэр, шатахуун	75,211,400.00	82,747,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,835,700.00	20,000,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000.00	740,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	14,631,845.46
2105	Нормативд зардал	17,387,502.00	9,999,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,387,502.00	9,999,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,500,000.00	66,309,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	8,337,300.00
210604	Урсгал засвар	38,000,000.00	57,972,300.00
2107	Томилолт, зочны зардал	72,806,500.00	69,575,000.00
210702	Дотоод албан томилолт	72,806,500.00	69,575,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	222,233,260.00	106,405,645.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,229,900.00	75,446,546.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.00	3,139,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	955,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000.00	329,880.40
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,597,960.00	18,442,030.00
210807	Газрын төлбөр	1,045,400.00	8,092,589.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,925,755,341.61	6,355,368,992.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,917,755,341.61	6,346,638,092.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	8,730,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,299,612,719.89	2,455,393,500.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	133,927,900.00	426,659,034.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	126,667,900.00	129,898,838.33
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	257,883,636.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,260,000.00	38,876,560.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,165,684,819.89	1,875,585,763.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,165,684,819.89	1,875,585,763.64
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	153,148,703.00

213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	153,148,703.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,500,000.00</u>	<u>-</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,500,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,500,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	19,500,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	19,500,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(19,500,000.00)</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,204,862,300.00	5,008,267,144.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,204,862,300.00	5,008,267,144.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,123,973,300.00	4,944,140,460.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,880,663,700.00	2,846,494,321.90
210101	Үндсэн цалин	1,513,923,400.00	1,480,734,280.55
210102	Нэмэгдэл	1,156,911,200.00	1,095,172,440.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	107,690,000.00	100,414,039.19
210104	Урамшуулал	102,139,100.00	170,173,562.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	343,208,100.00	339,126,388.03
210201	Тэтгэврийн даатгал	233,581,200.00	237,356,898.13
210202	Тэтгэмжийн даатгал	28,657,000.00	23,390,339.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,925,300.00	17,578,657.54
210204	Ажилгүйдлийн даатгал	5,731,300.00	5,327,730.64
210205	Эрүүл мэндийн даатгал	52,313,300.00	55,472,762.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	334,896,100.00	334,895,960.42
210301	Гэрэл, цахилгаан	58,967,300.00	58,967,233.53
210302	Түлш, халаалт	239,151,500.00	239,151,426.80
210303	Цэвэр, бохир ус	36,777,300.00	36,777,300.09

2104	Хангамж, бараа материалын зардал	143,408,100.00	142,605,540.46
210401	Бичиг хэрэг	24,525,000.00	24,486,205.00
210402	Тээвэр, шатахуун	82,747,300.00	82,747,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,439,800.00	20,000,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	981,000.00	740,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,715,000.00	14,631,845.46
2105	Нормативд зардал	10,006,200.00	9,999,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,006,200.00	9,999,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,338,500.00	66,309,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,338,500.00	8,337,300.00
210604	Урсгал засвар	58,000,000.00	57,972,300.00
2107	Томилолт, зочны зардал	69,575,000.00	69,575,000.00
210702	Дотоод албан томилолт	69,575,000.00	69,575,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,526,700.00	106,405,645.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,510,000.00	75,446,546.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,139,200.00	3,139,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	961,400.00	955,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	662,200.00	329,880.40
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,525,000.00	18,442,030.00
210807	Газрын төлбөр	8,728,900.00	8,092,589.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,168,350,900.00	1,028,728,704.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,159,620,000.00	1,019,997,804.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,730,900.00	8,730,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,889,000.00	64,126,684.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,889,000.00	64,126,684.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,225,800.00	46,463,484.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,663,200.00	17,663,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,204,862,300.00	5,008,267,144.54
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,184,862,300.00	4,999,077,011.54
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,184,862,300.00	4,999,077,011.54
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	9,190,133.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	9,190,133.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,126,640,041.00	7,807,871,644.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,089,689,005.94	5,964,922,466.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,089,689,005.94	5,602,390,116.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,317,213.44	57,100,594.90
210101	Үндсэн цалин	-	37,507,596.53
210102	Нэмэгдэл	-	6,859,313.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,060,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,317,213.44	8,673,684.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	6,047,928.94
210201	Тэтгэврийн даатгал	-	6,047,928.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	212,601,304.00
210302	Түлш, халаалт	-	212,601,304.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,600,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	131,600,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,934,771,792.50	5,326,640,288.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,934,771,792.50	5,326,640,288.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	362,532,350.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	362,532,350.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	83,435,354.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	257,883,636.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	21,213,360.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,036,951,035.06	1,842,949,178.18
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,036,951,035.06	1,689,800,475.18
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн гүйлгээ		153,148,703.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,126,640,041.00	7,807,871,644.44
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,126,640,041.00	7,807,871,644.44
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,006,043,877.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,059,515,462.00	3,606,541,469.94

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,227,681,943.00	1,083,196,692.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,839,442,636.00	1,112,089,605.00
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3,496,504.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,752,938.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн орлого буруу илэрхийлсэн 234,597.5 мянган төгрөг,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй 1,390,031.2 мянган төгрөг
- Авлагыг зөрүүтэй илэрхийлсэн 727,571.0 мянган төгрөг
- Үндсэн хөрөнгийн ангиллыг 381,146.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж нягтлан бодох бүртгэлийн стандарт хэрэгжүүлээгүй байгааг залрууллаа.

Залруулагдаагүй 743,566.2 мянган төгрөгийн зөрчил ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 743,566.2 мянган төгрөгийн 17 зөрчил² илэрснээс худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас зайлсхийж жижиглэн худалдан авалт хийсэн, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин сонин сэтгүүл хэвлэсэн, анхан шатны баримтгүй 147,816.0 мянган төгрөгийн 3 асуудлыг хуулийн байгууллагад хандан шалгуулахаар шилжүүлж, 5,625.6 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 172,181.4 сая төгрөгийн 3 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 417,943.3 мянган төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж бичигдлээ.

3.1 Хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудал:

3.1.1 Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын А/260, А/261, А/302, А/812 тоот захирамжаар 128,316.0 мянган төгрөгөөр Засаг даргын үйл ажиллагааны тайлан, сэтгүүл болон сонин хэвлүүлэхдээ Засгийн газрын тогтоолоор баталсан босго үнээс давсан байхад жижиглэн гэрээ хийж худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй материал хэвлүүлсэн нь гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.3-д “хэвлэл захилгын төлбөр” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй

Шийдвэрлэсэн нь: Хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах

¹ Мэдээллийг тусгахгүй орхиадуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.2 Илрүүлэлт: Аймгийн засаг даргын А/201 тоот захирамжаар 19,500.0 мянган төгрөгийн гэрээг Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоотой байгуулсан ч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй анхан шатны баримт нь өөр аймгийн нэртэй, гэрээнд заагдсан байгууллагуудад сургалт хийсэн нь баримтаар нотлогдохгүй гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах

3.2 Төлбөрийн акт

5.2.1 Илрүүлэлт: Аймгийн Засаг дарга нь тайлант онд 2 орлогч ажиллуулж 1,299.6 мянган төгрөгийн цалин олгосон,

5.2.2 Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын А/838 тоот захирамжаар сургалтад хамрагдсан хүүхдүүдэд хоол олгосон гэсэн баримтаар 4,326.0 мянган төгрөгийн зардал гаргасан байгаа нь нотлогдоогүй зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Нийслэлийн засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын засаг дарга нэгээс илүү орлогч ажиллуулахыг хориглоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага:

5.3.1 Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын тамгын газраас ажлаас халагдаж шүүхийн шийдвэрээр буцаан ажилд томилогдсон албан хаагчдад ажилгүй байсан хугацааны цалинд 96,945.4 мянган төгрөгийн цалинг олгоод буцаан буруутай этгээдээр төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлэх” гэж заасантай нийцээгүй

Шийдвэрлэсэн нь: Буруутай этгээдээр буцаан төлүүлэх ажлыг зохион байгуулах албан шаардлага бичлээ.

5.3.2. Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын А/132, А/818, А251 тоот захирамжуудаар эмэгтэйчүүдийн холбоонд 55,236.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ч санхүүгийн анхан шатны баримт дутуу, төсвийн үрэлгэн зардлыг санхүүжүүлсэн, Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг зөрчин иргэдийн санал аваагүй 20,000.0 мянган төгрөгөөр зардал санхүүжүүлэн Эйблсофт ХХК-д олгосон ч одоо программ хангамжийг ашиглахгүй, төсвийн үрэлгэн зардал санхүүжүүлсэн,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах”, 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 603.4-д “олон нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээний санхүүгийн баримтыг бүрдүүлж орон нутгийн сангийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага бичигдсэн.

3.4. Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын албан хаагчдад 97,176.9 мянган төгрөгийн үр дүнгийн нэмэгдэл зөрүүтэй олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журмын 2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай тус тус нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

3.4.2. Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Төрийн албан хаагчдыг гадаад улсад аялуулахад 108,414.8 мянган төгрөг зарцуулсан, Зэрэг сумын төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтад 3,130.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.4-д “Олон нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа” гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Сангийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэх, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

3.4.3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирсэн мөнгөн хөрөнгөөс 12 аж ахуйн нэгжид анхан шатны баримтгүйгээр 156,946.0 мянган төгрөг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг аж ахуйн нэгжүүдээс авч иж бүрдлийг ханган ажиллаж алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.4.4. Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын нягтлан бодогч нь шатахууны зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлээгүй баримтын иж бүрдлийг бүрэн бүрдүүлээгүйтэй холбоотойгоор 48,275.6 мянган төгрөг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан жолоочийн замын хуудсыг сар бүр хянаж хэвших

3.4.4. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамааралгүй бусад аймгуудад мэндчилгээ дэвшүүлэхэд 1,500.0 мянга, барилгын их засварын ажилд мэргэжлийн бус хүнээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан 2,500.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаалын хавсралтын 2.2.2-д "орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн шийдвэрийн дагуу хийх авто зам, барилга, инженерийн байгууламж болон шугам сүлжээний ажлын захиалагчийн хяналтыг батлагдсан төсөвт нь багтаан шаардлагатай инженер, техникийн ажилтныг гэрээгээр авч гүйцэтгүүлэх" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын ажилд хэрэгжүүлэх хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж өөрийн эрхлэх хүрээнд хамааралгүй үйл ажиллагаанд зардал гаргахгүй ажиллах

3.4.5. Тушаалын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн үйлчилгээний албан хаагчдын тушаалыг гаргахдаа ур чадварын нэмэгдлийг тусгасан зөрчил нь Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтын 2-д "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ", 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Төрийн үйлчилгээний албан хаагчдын тушаал гаргахдаа ур чадварын нэмэгдэл заасан заалтыг хасаж ажиллах.

3.4.6. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын ерөнхий нягтлан бодогч болон тооцооны нягтлан бодогч нь хамаарал бүхий хүн ажиллаж байгаа зөрчил нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Аймгийн ЗДТГ	Санхүүгийн тайланд орлогыг дутуу илэрхийлсэн	1	1,624,628.7	1	1,624,628.7			1	1,624,628.7				
	Авлагыг дутуу илэрхийлсэн.	1	747,163.6	1	747,163.6			1	747,163.6				
	Үндсэн хөрөнгийн ангиллыг зөрүүтэй тайлагнасан	1	381,146.2			1	381,146.2	1	381,146.2				
Нийт дүн		3	2,752,938.5	2	2,371,792.30	1	381,146.20	3	2,752,938.50	0	0	0	0

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Аймгийн ЗДТГ	А/380 тоот захирамжаар 12 аж ахуйн нэгжид анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн	1	156,946.0					1	156,946.0		
	ОНХС-гийн хөрөнгийг журам зөрчин зарцуулсан	1	115,544.8					1	115,544.8		
	Шатахууны зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй	1	48,275.6					1	48,275.6		

Үр дүнгийн нэмэгдлийг ЗГ-ын тогтоолын дагуу олгоогүй	1	97,176.9				1	97,176.9		
ОНХС-гийн журам зөрчин урсгал зардал санхүүжүүлсэн	1	75,236.0			1	75,236.00			
Нийт дүн	5	493,179.3			1	75,236.0	4	417,943.3	

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Аймгийн ЗДТГ	Ерөнхий нягтлан бодогч тооцооны нягтлан бодогч гар нь хамаарал бүхий, төрийн үйлчилгээний албан хаагчдын тушаалд ур чадварын нэмэгдлийг заасан.	1	-					1	0		
	Шүүхийн шийдвэрээр байгууллагад учирсан хохирлыг буцаан нэхэмжлээгүй	1	97,176.9			1	97,176.9				
	Аймгийн Засаг дарга нь 2 орлогч ажиллуулсан. Анхан шатны баримтаар нотлогдоогүй арга хэмжээг санхүүжүүлсэн.	1	5,625.6	1	5,625.6						
	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин хэвлэл мэдээллийн төлбөр төлсөн, анхан шатны баримт хангалтгүй	1	147,816.0								1
Нийт дүн	4	250,618.5	1	5,625.6	1	97,176.9	1	0	1	147,816.0	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1					1	
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1					1	